



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 25 өдөр

Дугаар: 1/261

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын радио холбоо зохион байгуулах, ашиглах журам"-ыг 1 дүгээр, "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын телефон холбоо зохион байгуулах, ашиглах журам"-ыг 2 дугаар, "Онцгой байдлын ерөнхий газрын албан тушаалтны телефон ярианы эрх, сарын лимит"-ийг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (онцгой байдлын хурандаа Д.Дарь Сүхбаатар)-д даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2007 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 233 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХУРАНДАА



ДУЛАМДОРЖ

Онцгой байдлын ерөнхий газрын
дартын 2013 оны 4 дүгээр сарын
25-ны өдрийн дугаар тушаалын
дугаар хэвсрэлт

ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН РАДИО ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд байнгын болон гамшгийн үед радио холбоог тасралтгүй найдвартай шуурхай зохион байгуулж хангахад оршино.

1.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд радио холбоогоор мэдээ нэвтрүүлэх, хүлээн авах, өгөгдөл дамжуулах, дүрс, зарлан мэдээлэл явуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, радио станцын бичиг баримтыг хөтлөхөд энэхүү журмыг мөрдөнө.

1.3. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно;

1.3.1. "Бэлтгэл үелзэл" гэж мэдээлэл солилцох ажлын үелзэл буюу сувагт ямар нэгэн саатуулга бий болох үед ахлах станцын шийдвэрээр шилжин ажиллах үелзэл буюу сувгийг;

1.3.2. "Радио давтамжийн зурвас" гэж бүлэг радио давтамжийг;

1.3.3. "Радио долгион" гэж агаарын орон зайд тархаж байгаа цахилгаан соронзон орны 3000 мега герц хүртэлх давтамжтай хэсгийг;

1.3.4. "Радио холбоо" гэж радио төхөөрөмж ашиглан төрөл бүрийн мэдээллийг тэмдэгт, дохио, дуу, дүрс болон бусад хэлбэрээр нэвтрүүлэх, хүлээн авахыг;

1.3.5. "Үндсэн үелзэл" гэж мэдээлэл солилцох ажлын үелзэл буюу сувгийг;

1.4. Радио холбооны төлөвлөлт, зохион байгуулалт, радио давтамжийн хуваарилалт, тоног төхөөрөмжийн шинэчлэл, өргөтгөл, ашиглалтын хэвийн ажиллагаа, бүх төрлийн техникийн үйлчилгээг мэдээлэл холбоо хариуцсан нэгж хариуцаж ажиллана.

Хоёр. Радио холбооны зохион байгуулалт

2.1. Радио холбоог онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд радио чиг, радио тор, жижүүрийн хүлээн авалтын горим, бүлгээр сонгох горимын аргаар зохион байгуулж ашиглана.

2.1.1. "Радио чиг"-ийн аргаар радио холбоог зохион байгуулахдаа хоёр хэрэглэгчийн хооронд радио холбоогоор хангахаар тусгай өгөгдсөн долгион дээр ажиллаж байхаар хоёр станцыг холбоно.

2.1.2. "Радио тор"-ын аргаар радио холбоог зохион байгуулахдаа өгөгдсөн нэг үелзэл /долгион/ дээр хэд хэдэн станц зэрэг ажиллаж, ахлах станцын захирамж, мэдээллийг хүлээн авч, хариу өгөхдөө хатуу эрэмбэтэйгээр цуварч холбоонд орж харилцан мэдээлэл солилцоно.

2.1.3. "Жижүүрийн хүлээн авалтын горим"-д ажиллахдаа бүх станцад урьдчилан тохируулсан үелзлээс ахлах станцын өгсөн нэг үелзэл дээр станцууд байнгын хүлээн авалтад байж өгөгдөх команд, дохиог хүлээн авна. Ахлах станц нь холбогдох шаардлагатай станцын үелзэл дээр тавьж мэдээлэл дамжуулна. Энэ нөхцөлд долгионы тархалт харилцан адилгүй өөр өөр үелзэл дээр ашиглагдах бөгөөд станцын үелзэл хайх горимыг давхар сонгон ажиллуулж болно.

2.1.4. "Бүлгээр сонгох горим"-ыг тоон радио станц дээр хэрэглэх бөгөөд урьдчилан сонгосон сувгуудад хэд хэдэн станцыг нэг бүлэг болгон хувааж ахлах станц томилон ашиглана.

2.2. Радио холбоонд ахлах даргын холбоог хангаж байгаа радио станц нь ахлах станц болно.

2.3. Радио давтамжийг сонгохдоо Харилцаа, холбооны зохицуулах хорооноос хуваарилсан зурвасын хүрээнд газар орны байрлал, долгионы нягтралыг тооцоолж хуваарилна. (1 дүгээр хавсралт)

2.4. Радио станц бүрт радио өгөгдөхүүн өгнө. Өгөгдөхүүнийг радио станцын үндсэн болон бэлтгэл үелзэл, ажлын төрөл дуудлага, харилцагчийн байршил, холбоонд орох хугацаа зэргээр тодорхойлно.

2.5. Ажлын төрлийг байнгын болон аюулт үзэгдэл, ослын үед радио холбоо зохион байгуулж байгаа төв, орон нутгийн анги, байгууллага, дээд шатны байгууллагын зааврын дагуу зохион байгуулна.

2.6. Радио холбоог зохион байгуулахдаа дээрээс доош, баруунаас зүүн тийш шилжих холбооны үндсэн зарчмыг баримтална.

2.7. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын радио станцын харилцах нэр, дуудлагыг Онцгой байдлын ерөнхий газраас төв орон нутгийн анги, байгууллага руу, төв орон нутгийн анги, байгууллагаас салбар нэгжүүд руу газар орон, нуур, гол мөрний нэрийг ашиглан өгч, нэгжийн даргаар батлуулна. (2 дугаар хавсралт)

2.8. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд "Харилцан ажиллагааны радио холбооны бүдүүвч"-ийн дагуу радио холбоонд орно. (3 дугаар хавсралт)

2.9. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага нь харилцан ажиллах байгууллагатай зохицон ажиллах боломж бүхий радио холбооны техник хэрэгсэл, радио өгөгдэхүүнтэй байна.

2.10. Радио станцаар харилцахдаа яриаг нууцлаж, тоон утгаар орлуулж, шаардлагатай тохиолдолд нууцлах төхөөрөмж ашиглаж болно.

Гурав. Радио холбооны хүч хэрэгсэл

3.1. Радио холбоо нь богино долгионы, хэт богино долгионы аналог болон тоон радио станц, сансрын холбооны төхөөрөмж, байршил тогтоох системээс бүрдэнэ. Төв орон нутгийн анги, байгууллага нь үйл ажиллагааны онцлогтоо тохирсон радио холбооны техник хэрэгсэлтэй байна.

3.2. Онцгой байдлын ерөнхий газар, төв орон нутгийн анги, байгууллагын шуурхай удирдлагын байранд богино, хэт богино долгионы радио станцыг суурин байдлаар, тусгай зориулалтын автомашинд богино, хэт богино долгионы радио станцыг хөдөлгөөнт байдлаар, нөөц цахилгаан тэжээлийн хамтаар тоногосон байна.

3.3. Төв орон нутгийн анги, байгууллага нь ээлжийн бүрэлдэхүүн, шуурхай бүлэг, хариуцлагатай эргүүл үүрэг гүйцэтгэхэд хэрэглэх богино, хэт богино долгионы зөөвөр /үүргэвч/-ийн станц, сансрын холбооны станц, байршил тогтоох төхөөрөмж, хэт богино долгионы гар станцыг нөөц тэжээлийн хамт байнгын бэлэн байдалд байлгана.

3.4. Хэт богино долгионы радио холбооны тархалтыг сайжруулах зорилгоор газар зүйн нөхцөл байдалд тохируулан өндөрлөг газарт эсвэл зориулалтын цамхагт дахин дамжуулах станцыг байрлуулна.

Дөрөв. Радио холбооны ашиглалт

4.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд радио холбооны бүх төрлийн сүлжээг ашиглан холбоо тогтооно.

4.2. Онцгой байдлын ерөнхий газраас төв, орон нутгийн анги, байгууллагатай 24 цагийн турш тэгш тоотой хоёр цаг тутамд холбооны чанар байдлыг шалгаж мэдээлэл солилцоно.

4.3. Төв, орон нутгийн анги, байгууллагаас салбар, нэгжүүдтэй 24 цагийн турш сондгой тоотой хоёр цаг тутам холбогдож холбооны чанар байдлыг шалгаж мэдээлэл хүлээн авна.

4.4. Аюулт үзэгдэл, ослын үед радио холбоог "Жижүүрийн хүлээн авалтын горим"-д байнгын ажиллуулж, шаардлагатай мэдээ мэдээллийг тухай бүр нь дамжуулж, гамшгийн төрөл, газар орны байрлал, хүн хүч, техникийн боломжийг тодорхойлон дээд шатны байгууллагатай гамшгийн голомтоос нэг цаг тутам холбогдож бэлэн байдлыг ханган ажиллана.

4.5. Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед төв, орон нутгийн анги, байгууллагын даргын шийдвэрээр байнгын байрлалд болон гамшгийн голомтод холбоог жижүүрийн хүлээн авалтын горимоор ажиллуулна.

4.6. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх шуурхай бүлгийн бүрэлдэхүүнд тусгай холбоочинг томилон шаардлагатай холбооны техник хэрэгслээр ханган, бүлгийн дарга нарт хэт богино долгионы гар станцыг олгож, цагийн байдлын тухай мэдээллийг шуурхай хүлээн авч, нэгтгэнэ.

4.7. Гамшгийн үед үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын холбоог ашиглан төв станцтай холбогдох нөөц төлөвлөгөөтэй байна.

4.8. Төв орон анги, байгууллага, салбар нэгжүүд шилжилт хөдөлгөөн үйлдэж цуваанд явахдаа цувааны удирдагч, чиглүүлэгч, цоожлогч нь хэт богино долгионы радио холбоогоор холбогдоно.

4.9. Цувааны удирдагч буюу ахлах станц нь шуурхай удирдлагын байр руу хөдөлгөөний талаарх мэдээллийг радио холбоогоор байнга өгч ажиллана.

Тав. Радио холбоо тогтоох

5.1. Радио холбоогоор мэдээлэл солилцохдоо мэдээний эхэнд, төгсгөлд нь харилцагчийн болон өөрийн дуудлагыг заавал нэвтрүүлж холбооны сахилга батыг чанд сахиж ажиллана. (4 дүгээр хавсралт)

5.2. Суурин радио станцад холбоонд орсон цагийн бүртгэл, холбооны дэвтэр хөтлөнө. Холбоонд орсон цагийн бүртгэл, холбооны дэвтэр нь радио станцын ажиллагаа, мэдээ нэвтрүүлэх, хүлээн авах, өгөгдөл дамжуулах, дүрс, тэмдэгт зарлан мэдээлэл явуулах, дохионы ажиллагааг тусгах үндсэн бичиг баримт болно.

5.3. Холбоонд орсон цагийн бүртгэлийг суурин радио станц дээр ажиллаж буй албан хаагч хөтлөнө. (5 дугаар хавсралт)

5.4. Радио холбооны чанарыг харилцагчийн сонсголын байдлаар "онц", "сайн", "дунд", "муу" гэж үнэлнэ.

5.5. Радио холбоог байнгын хүлээн авалтад бэлэн байлгах бөгөөд ахлах станц радио холбооны бэлэн байдлыг хянах зорилгоор ямар ч үед шалгаж болно. Радио холбоогоор харилцах болон шалгахдаа богино дохио, тусгай мэдээ, тоон утга бүхий нууц мэдээ, өгөгдөл дамжуулах замаар гүйцэтгэнэ.

5.6. Ахлах станц нь бусад станцад тогтоосон ажлын горим, холбооны сахилга батыг сахиулж, мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохицуулан хяналт тавьж ажиллана. Ахлах станцын тавьсан шаардлагыг бусад станцууд биелүүлэх үүрэгтэй.

Зургаа. Хориглох зүйл

6.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын радио холбоог зориулалтын бусаар ашиглах;

6.2. Улсын болон байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг радио холбоогоор илээр нэвтрүүлэх;

6.3. Радио холбооны техник хэрэгслийг бусдад дамжуулан ашиглуулах;

6.4. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын радио давтамжийг зориулалтын бусаар ашиглах;

6.5. Радио холбоогоор дамжуулсан мэдээллийг бусдад дамжуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дур мэдэн олон нийтэд мэдээлэх;

Долоо. Бусад зүйл

7.1. Радио холбооны техник хэрэгсэлтэй ажиллах албан хаагч нь радио холбоог ашиглах зааврыг мөрдлөг болгон тухайн ажиллах радио холбооны өгөгдөхүүнийг судалж мэдсэн байна.

7.2. Радио холбооны техник тоног төхөөрөмж, антенн фидерийн байгууламж, ашиглах, засварлах, суурилуулах албан хаагч нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, заавартай танилцаж мөрдлөг болгон ажиллана.

7.3. Журмын биелэлтэд мэдээлэл холбоо хариуцсан нэгж, төв орон нутгийн анги байгууллагын удирдлага хяналт тавьж ажиллана.

7.4. Энэхүү журмыг зөрчсөн албан хаагчид Төрийн албаны тухай хууль, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн сахилгын дүрмийн дагуу сахилгын шийтгэл ноогдуулна.

-----oOo-----

Онцгой байдлын ерөнхий газрын
даргын 2013 оны 1 дүгээр сарын
25-ны өдрийн тушаалын
2 дүгээр хавсралт

ТЕЛЕФОН ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн анги, байгууллагын телефон холбоог төлөвлөх, зохион байгуулах, бэлэн байдлыг хангах, ашиглахад энэхүү журмыг дагаж мөрднө.

1.2. Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн анги, байгууллагын телефон холбооны төлөвлөлт, сувгийн гадаад, дотоод холболт, өргөтгөл, ашиглалтын хэвийн ажиллагаа, засвар, үйлчилгээг мэдээлэл, холбоо хариуцсан, нэгж /цаашид "үйлчлэгч" гэх/ телефон холбооны ашиглалтын гэрээ, төлбөр тооцоо, шинэчлэл, нөхөн хангалтыг санхүү, ар тал хариуцсан нэгж хариуцан ажиллана.

Хоёр. Телефон холбоог зохион байгуулах

2.1. Телефон холбоонд Онцгой байдлын ерөнхий газрын бүх төрлийн хөдөлгөөнт ба суурин телефон утас, дамжуулах шугам болон төгсгөлийн төхөөрөмж багтана.

2.2. Албан тушаалтны /цаашид "хэрэглэгч" гэх/ ажлын хэрэгцээнд бүх төрлийн телефон холбоог зохион байгуулж хангана.

2.3. Телефон холбоог удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалтан гэсэн дарааллаар зохион байгуулна.

2.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед ажиллах шуурхай бүлэг, ажлын хэсгийг сансрын хөдөлгөөнт холбоо, үүрэн болон суурин телефон холбоогоор хангаж ажиллана.

Гурав. Телефон холбооны ашиглалт

3.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч дараах зориулалтаар телефон холбоог ашиглана. Үүнд:

3.1.1. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нар сансрын хөдөлгөөнт холбоо, улс, хот хоорондын эрхтэй үүрэн болон суурин утас, факсын болон цахим утсыг тодорхой хязгаартайгаар,

3.1.2. Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын

үед мэдээ, мэдээлэл хүлээн авах, дамжуулах үүрэгтэй албан тушаалтан хот хоорондын эрхтэй суурин утас, факсын телефон утсыг тодорхой хязгаартайгаар;

3.1.3. Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн мэргэжилтэн, шалган нэвтрүүлэгч, тавиулангийн жижүүр нар ердийн эрхтэй суурин телефон утсыг тодорхой хязгаартайгаар.

3.2. Телефон утасны ярианы хязгаарыг мэдээлэл, холбоо хариуцсан нэгж гаргаж, санхүү, ар тал хариуцсан нэгж батална.

3.3. Телефон холбоонд сансрын, хөдөлгөөнт, суурин, цахим телефон утас, хоёр буюу түүнээс дээш хэрэглэгчийн хооронд мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авахад хэрэглэх холбооны шугам, тэдгээрийг хамгаалахад хэрэглэдэг тусгаарлагч болон хуваарилах хайрцаг, залгуур багтана.

3.4. Телефон холбооны хуваарилах хайрцгийг битүүмжилж, сувагчлал, багана, цамхаг болон бусад хэрэгслийг гадны нөлөөнөөс хамгаалах арга хэмжээг авч мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

Дөрөв. Телефон холбооны хэрэглэгчийн эрх, үүрэг

4.1. Хэрэглэгч нь ажлын байрны тодорхойлолт, эрхлэж буй албан тушаалын шаардлагад нийцсэн телефон холбооны үйлчилгээг авах;

4.2. Телефон холбооны аппарат, утас, шугамд гэмтэл гарсан тохиолдолд холбоо, мэдээлэл хариуцсан нэгжид мэдэгдэж, засварлуулах арга хэмжээ авах;

4.3. Телефон утасны бүрэн бүтэн байдалд анхаарч, ярианы хязгаарт тохируулан ашиглах;

4.4. Телефон холбооны сүлжээгээр дамжиж буй мэдээ, мэдээллийн нууцлалыг сахих, хадгалах;

4.5. Телефон холбооны тоног төхөөрөмж, телефон утсыг дур мэдэн өөрчлөх, бусдад шилжүүлэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

Тав. Телефон холбоогоор үйлчлэгчийн эрх, үүрэг

5.1. Ажлын байранд байгаа холбооны шугам, тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээ хийх нөхцөл боломжийг хангах;

5.2. Сансрын болон суурин телефон утасны ярианы хязгаар дуусч хаагдсанаас бусад тохиолдолд телефон холбоог байнга бэлэн байлгах;

5.2. Телефон холбооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, өргөтгөх, үйлчилгээний зориулалтыг өөрчлөх, түр зогсоох үед хэрэглэгчидэд урьдчилан мэдэгдэх;

5.3. Телефон холбооны шугам, телефон утсанд гарсан гэмтлийг шуурхай тодорхойлон засварлах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандах;

5.4. Телефон холбооны хуваарилах хайрцгийг эмх цэгцтэй байлгаж, телефон сүлжээний бүдүүвчтэй байх;

5.5. Телефон холбооны сувагчлалгүй газар (хичээлийн байр, сургалтын танхим гэх мэт), нэгдсэн арга хэмжээний үеэр телефон холбооны шугам татаж холбоо зохион байгуулах;

5.6. Телефон утасны гэрээг шинэчилэх, шаардлагатай нэмэлт үйлчилгээг холбогдох нэгжид танилцуулж баталгаажуулах;

5.7. Шаардлагатай тохиолдолд хэрэглэгчийн ярианы хязгаарт санхүү, ар тал хариуцсан нэгжийн зөвшөөрлөөр өөрчлөлт оруулах;

5.8. Өрөө тасалгаа, хэрэглэгчийн тоо өөрчлөгдсөн тохиолдолд тамгын газар, мэдээлэл холбоо, санхүү хариуцсан нэгж хамтран ярианы хязгаарыг шинэчлэн тодотгол хийнэ.

Зургаа. Хяналт, шалгалт

6.1. Телефон холбооны ашиглалтын байдалд мэдээлэл, холбоо хариуцсан нэгж, төлбөр тооцооны зарцуулалтад санхүү хариуцсан нэгж хяналт тавьж ажиллана;

6.2. Энэхүү журмыг зөрчигчид холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----